



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 08 сарын 16 өдөр

Дугаар А/516

Алтай хот

**Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3 дахь заалт, 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалт, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 86 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх ГААОНӨГ/202203061 дугаартай "108 сая мод тарих" арга хэмжээний хүрээнд Алтай хотод ногоон байгууламжийн хашаа, хайс хийх ажлыг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Т. Сүхбаатар)-д олгосугай.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулан, хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийг тайлагнаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Т.Сүхбаатар)-д үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Хурцгэрэл), Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар)-т тус тус даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2022 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн А/394 дүгээр захирамж хүчингүй болсонд тооцсугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ